



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/526

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалт, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үйлчилгээ, засвар хийх журмын 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ангилал тогтоох, тохирлын гэрчилгээ олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхцэцэг - (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Л.Намсрай - (Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн хэмжүүрийн улсын шалгагч)

Ц.Наранчимэг - (Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтын шинжээч)

Н.Алтанбагана - (Мэргэжлийн хяналтын газрын автотээврийн хяналтын улсын байцаагч)

Х.Мягмарсүрэн - (Мэргэжлийн хяналтын газрын хэмжилзүйн хяналтын улсын байцаагч)

Д.Бат-Эрхэм - (Автотээврийн төвийн автотээврийн хяналтын улсын байцаагч)

Л.Батгэрэл - (Автотээврийн төвийн автотээврийн хяналтын улсын байцаагч)

0201301824

2.

- Ц.Амарсанаа -(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
- П.Ууганбаяр -(Цагдаагийн газрын экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах цагдаагийн ахмад)
- Б.Жавзмаа -(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол, хог хаягдал, химийн хорт бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Т.Мөнхнасан -(Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн дарга)

2.Үзлэг шалгалтыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу явуулан аттестатчилах, тохирлын гэрчилгээ олгох арга хэмжээг авч ажиллан, дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Ж.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ